

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/93-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын газрын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6-7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8-9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11-12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13-14
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15-16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16-17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17-18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18-19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт	20
4.3 Зөвлөмж	20-21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БГАУ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.24 № СЭА-2022/93-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,632,456.70	57,038,657.08
33	АВЛАГА	24,235,616.00	4,575,943.08
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,403,277.00	1,238,822.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	22,832,339.00	3,337,121.08
35	БАРАА МАТЕРИАЛ	45,396,840.70	52,462,714.00
35100	Түүхий эд материал	2,520,840.00	3,055,440.00
35110	Тусгай зориулалттай материал	2,520,840.00	3,055,440.00
35400	Хангамжийн материал	42,876,000.70	49,407,274.00
35410	Бичиг хэргийн материал	7,433,576.70	5,041,650.00
35420	Аж ахуйн материал	28,128,974.00	38,714,774.00
35440	Түлш, шатах тослох материал	5,884,600.00	4,222,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,428,850.00	1,428,850.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	422,896,239.11	466,732,494.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	422,896,239.11	466,732,494.26
39200	Биет хөрөнгө	414,028,239.11	448,514,494.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,724,015.00	120,724,015.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(896,535.36)	(1,344,803.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	362,191,750.00	264,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(116,945,916.61)	(66,412,500.16)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	369,256,808.86	386,096,676.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	(214,070,306.77)	(267,287,021.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,573,997.00	37,773,997.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,805,573.01)	(25,235,870.18)
39300	Биет бус хөрөнгө	8,868,000.00	18,218,000.00
39301	Программ хангамж	1,730,000.00	1,730,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,730,000.00)	(1,730,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,868,000.00	18,218,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	492,528,695.81	523,771,151.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	492,528,695.81	523,771,151.34
51	Засгийн газрын хувь оролцоо	492,528,695.81	523,771,151.34
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	157,557,480.26	157,557,480.26
51200	Хуримтлагдсан үр дүн	328,403,450.55	359,645,906.08
51210	Өмнөх үеийн үр дүн	63,114,618.85	328,403,450.55
51220	Тайлант үеийн үр дүн	265,288,831.70	31,242,455.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,567,765.00	6,567,765.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	492,528,695.81	523,771,151.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,132,266,757.40	848,584,895.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109,159,347.40	175,681,994.00
120	Нийтлэг татварын бус орлого	109,159,347.40	175,681,994.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,580,310.70	107,268,126.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,580,310.70	107,268,126.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	62,389,868.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,579,036.70	6,024,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,023,107,410.00	672,902,901.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,303,600.00	559,695,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,303,600.00	559,695,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	410,877,122.00	97,646,401.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	410,877,122.00	97,646,401.08
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,805,900.00	15,561,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,805,900.00	15,561,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	120,788.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	120,788.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	866,977,925.70	815,534,106.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	866,977,925.70	815,534,106.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	740,150,878.07	679,873,047.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,633,813.07	420,866,564.25
210101	Үндсэн цалин	316,614,258.10	307,443,214.25
210102	Нэмэгдэл	84,659,954.97	93,056,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,295,400.00	10,937,950.00
210104	Урамшуулал	1,800,000.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,264,200.00	9,429,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,705,300.00	56,925,136.96
210201	Тэтгэврийн даатгал	40,229,800.00	38,304,136.96
210202	Тэтгэмжийн даатгал	4,180,700.00	6,031,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,077,700.00	3,357,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	855,700.00	839,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,361,400.00	8,393,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,519,800.00	15,370,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,170,200.00	2,170,200.00
210302	Түлш, халаалт	4,479,900.00	4,330,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,810,900.00	2,810,900.00
210304	Байрны түрээс	6,058,800.00	6,058,800.00

**Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	Хангамж, бараа материалын зардал	61,551,599.98	63,418,166.70
210401	Бичиг хэрэг	17,311,089.98	14,927,426.70
210402	Тээвэр, шатахуун	34,773,600.00	37,341,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	649,900.00	732,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,817,010.00	10,416,500.00
2105	Нормативт зардал	1,345,122.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,345,122.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,170,200.00	835,900.00
210604	Урсгал засвар	11,170,200.00	835,900.00
2107	Томилолт, зочны зардал	17,787,300.00	6,662,100.00
210702	Дотоод албан томилолт	17,787,300.00	6,662,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,930,575.00	12,821,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,862,375.00	10,264,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	145,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	391,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,400.00	22,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,045,800.00	1,997,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,507,168.02	102,972,789.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,750,113.00	1,227,510.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,757,055.02	101,745,279.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	126,827,047.63	135,661,058.79
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,834,888.00	4,720,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	120,788.00	0.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	4,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,184,700.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,529,400.00	0.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,580,310.70	130,100,465.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,580,310.70	130,100,465.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,411,848.93	840,593.79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,411,848.93	840,593.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	265,288,831.70	33,050,789.04
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,808,333.51
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	1,808,333.51
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	265,288,831.70	31,242,455.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,129,378,424.70	803,003,366.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,580,310.70	130,100,465.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,580,310.70	130,100,465.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,580,310.70	130,100,465.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,580,310.70	130,100,465.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,034,798,114.00	672,902,901.08
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,303,600.00	559,695,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,303,600.00	559,695,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	422,567,826.00	97,646,401.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	422,567,826.00	97,646,401.08
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,805,900.00	15,561,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,805,900.00	15,561,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	120,788.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	120,788.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	811,137,964.70	718,003,366.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,137,964.70	718,003,366.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,855,378.07	579,005,186.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,845,368.07	420,702,109.25
210101	Үндсэн цалин	308,137,013.10	307,278,759.25
210102	Нэмэгдэл	92,414,554.97	93,056,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,229,600.00	10,937,950.00
210104	Урамшуулал	1,800,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	19,264,200.00	9,429,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,658,200.00	56,925,136.96
210201	Тэтгэврийн даатгал	39,870,500.00	40,138,636.96
210202	Тэтгэмжийн даатгал	4,196,900.00	4,196,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,357,500.00	3,357,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	839,500.00	839,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,393,800.00	8,393,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,519,800.00	15,370,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,170,200.00	2,170,200.00
210302	Түлш, халаалт	4,479,900.00	4,330,600.00
210303	Цэвэр, бохир ус	2,810,900.00	2,810,900.00
210304	Байрны түрээс	6,058,800.00	6,058,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,462,000.00	61,040,840.00

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	7,726,700.00	11,166,700.00
210402	Тээвэр, шатахуун	36,895,600.00	33,204,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	649,900.00	732,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,189,800.00	15,936,800.00
2105	Нормативт зардал	1,345,122.00	396,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,345,122.00	396,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,429,600.00	4,961,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,110,000.00	-
210604	Урсгал засвар	12,319,600.00	4,961,000.00
2107	Томилолт, зочны зардал	17,787,300.00	6,662,100.00
210702	Дотоод албан томилолт	17,787,300.00	6,662,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,180,275.00	11,719,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,157,875.00	11,160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	145,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	391,990.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,400.00	22,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,627,713.00	1,227,510.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,627,713.00	1,227,510.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,282,586.63	138,998,179.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,458,088.00	4,720,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	120,788.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,152,600.00	4,720,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,184,700.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,580,310.70	130,100,465.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,580,310.70	130,100,465.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	22,832,339.00	3,337,121.08
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	22,832,339.00	3,337,121.08
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,411,848.93	840,593.79
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,411,848.93	840,593.79
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	318,240,460.00	85,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	318,549,200.00	85,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	318,549,200.00	85,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	318,549,200.00	85,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	318,549,200.00	85,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(318,549,200.00)	(85,000,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(308,740.00)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	308,740.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	63,255,878.85	227,381,124.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(141,260.00)	(141,260.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	63,114,618.85	227,239,864.11
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	265,288,831.70	265,288,831.70
10	2020 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	328,403,450.55	492,528,695.81
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	328,403,450.55	492,528,695.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	328,403,450.55	492,528,695.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	31,242,455.53	31,242,455.53
20	2021 оны 12-р сарын 31-нээх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	359,645,906.08	523,771,151.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,256,500.00	574,415,906.21	840,593.79	99.85
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	575,256,500.00	574,415,906.21	840,593.79	99.85
210	Бараа, үйлчилгээний зардал	571,516,500.00	570,675,906.21	840,593.79	99.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,689,600.00	418,902,109.25	787,490.75	99.81
210101	Үндсэн цалин	307,792,800.00	307,278,759.25	514,040.75	99.83
210102	Нэмэгдэл	93,056,100.00	93,056,100.00	-	100.00
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	11,211,400.00	10,937,950.00	273,450.00	97.56
210105	Гэрээт ажлын хөлс	7,629,300.00	7,629,300.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,725,400.00	56,700,136.96	25,263.04	99.96
210201	Тэтгэврийн даатгал	39,938,900.00	39,913,636.96	25,263.04	95.34
210202	Тэтгэмжийн даатгал	4,196,600.00	4,196,600.00	-	143.71
210203	ҮОМШӨ ний даатгал	3,357,300.00	3,357,300.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	839,300.00	839,300.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,393,300.00	8,393,300.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,370,500.00	15,370,500.00	-	100.00
210301	Гэрэл цахилгаан	2,170,200.00	2,170,200.00	-	100.00
210302	Түлш, халаалт	4,330,600.00	4,330,600.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	2,810,900.00	2,810,900.00	-	100.00
210304	Байрны түрээс	6,058,800.00	6,058,800.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,939,900.00	42,232,850.00	1,050.00	93.98
210401	Бичиг хэрэг	6,276,700.00	6,276,700.00	-	70.40
210402	Тээвэр (шатахуун)	30,197,300.00	30,196,700.00	600.00	97.28
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	499,900.00	499,900.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	7,966,000.00	7,965,550.00	450.00	99.65
2105	Нормативт зардал	396,000.00	396,000.00	-	100.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	396,000.00	396,000.00	-	100.00
2106	Эд хогшил худалдан авах	15,190,700.00	15,190,700.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	190,700.00	190,700.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,662,100.00	6,662,100.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	6,662,100.00	6,662,100.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,328,000.00	11,328,000.00	-	123.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,160,000.00	11,160,000.00	-	124.25
210803	Даатгалын үйлчилгээ	145,600.00	145,600.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,400.00	22,400.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,214,300.00	1,187,510.00	26,790.00	97.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,214,300.00	1,187,510.00	26,790.00	97.79
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,740,000.00	3,740,000.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,740,000.00	3,740,000.00	-	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,740,000.00	3,740,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575,256,500.00	575,256,500.00	-	100.00

**Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	559,695,300.00	559,695,300.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	559,695,300.00	559,695,300.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,561,200.00	15,561,200.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	15,561,200.00	15,561,200.00	-	100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
	АЖИЛЛАГСДЫН ТОО	40.00	40.00	-	100.00
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00	-	100.00
	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,035,487.00	30,309,280.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	153,035,487.00	30,309,280.00
210	Бараа, үйлчилгээний зардал	145,435,487.00	29,329,280.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,000,000.00	1,800,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,800,000.00	1,800,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,200,000.00	225,000.00
210201	Тэтгэврийн даатгал	4,450,000.00	225,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,450,000.00	16,101,990.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	4,890,000.00
210402	Тээвэр (шатахуун)	2,850,000.00	3,007,900.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	950,000.00	232,840.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	950,000.00	7,971,250.00
2106	Эд хогшил худалдан авах	66,992,700.00	10,770,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	54,959,200.00	3,800,000.00
210602	Тавилга	12,033,500.00	2,200,000.00
210604	Урсгал засвар	1,410,000.00	4,770,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,410,000.00	391,990.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,871,500.00	391,990.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	1,871,500.00	40,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,761,287.00	40,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,761,287.00	980,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,600,000.00	980,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,600,000.00	980,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,600,000.00	64,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	246,700,000.00	64,000,000.00
220001	Барилга байгууламж	246,700,000.00	60,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	246,700,000.00	4,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	422,567,826.00	97,646,401.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	422,567,826.00	97,646,401.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	422,567,826.00	97,646,401.08
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын / цаашид Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар гэх / 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим системд шивэгдээгүй, нотлох дэмжих боломжгүй бараа материалын худалдан авалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь “Сэлэнгэ аймгийн газар нутгийн нөөц чадавхыг дэмжин тэтгэсэн эдийн засгийн хувьд ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй газар ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, эрх зүйн баталгаатай газар өмчлөл, эзэмшилт, ашиглалтыг бий болгоно.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын оршин тогтнох эх үүсвэр болсон газрыг иргэдэд тэгш, хуваарьтайгаар олгох,
- Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх, газрын кадастрын мэдээллийн санг бүрдүүлэх,
- Аймаг, сумын газрын харилцааны үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэгчдийн чадавхыг бэхжүүлэх, ил тод шуурхай байдлыг дээшлүүлэх.

Тайлант хугацаанд сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мөрдөж байгаа НББ-ийн бодлогын баримт бичгийг ГЗБГЗЗГ-аас 2012 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 866,977.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,004.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 9,753.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,593.8 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,403.3	4,575.9	3,172.6
Урьдчилгаа	22,832.3		(22,832.3)
Бараа материал	45,396.8	52,462.7	7,065.9
Үндсэн хөрөнгө	422,896.2	466,732.5	43,836.3
Нийт хөрөнгө	492,528.6	523,771.1	31,242.5
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	492,528.6	523,771.1	31,242.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	492,528.6	523,771.1	31,242.5

Авлага дансны үлдэгдэл 3,172.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 3,337.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлснээс голлон шалтгаалсан байна.

2020 онд УТХО-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 22,832.3 мянган төгрөгийн барилгын техник хяналтын зардлыг урьдчилгаа дансанд тусгасныг тайлант онд барагдуулж, ГЗБГЗЗГ-ын 100900029004 дугаар дансанд төвлөрүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52,462.7 мянган төгрөг болж 7,065.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн санхүүжилтээр нийт 66,247.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон ГЗБГЗЗГ-аас 5,600.0 мянган төгрөгийн үнэт цаас, гэрчилгээ, Сод монгол групп ХХК-иас шатахууны талоны урамшуулал 424.0 мянган төгрөг зэрэг нийт 6,024.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, нийт 65,205.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 828,742.6 мянган төгрөг болж өмнөх оноос 49,398.1 мянган төгрөгөөр өссөн нь нийт 135,000.0 мянган төгрөг / 4 айлын орон сууц 114,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 13,800.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 7,200.0 мянган төгрөг / -ийн хөрөнгийг төсвийн санхүүжилтээр худалдан авсан болон нийт 12,389.8 мянган төгрөг / 4 айлын орон сууцны газар 9,350.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 3,039.8 мянган төгрөг / -ийн хөрөнгийг үнэ

төлбөргүйгээр хүлээн авч, ТӨБЗГ-ын даргын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 171 дүгээр тогтоолын дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 97,991.7 мянган төгрөг / 82,491.7 мянган төгрөгийн үнэтэй Прадо-76, 15,500.0 мянган төгрөгийн үнэтэй Старекс авто тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдсан байна./-ийн балансын үнэтэй 2 авто тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 523,771.1 мянган төгрөг болж 31,242.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь өмнөх оноос 283,681.9 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар буурсан нь нэмэлт санхүүжилтийн орлого 313,230.7 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь өмнөх оноос 72,263.6 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 11,634.9 мянган төгрөг / гэрээт ажилтны цалин 9,834.9 мянган төгрөгөөр, урамшууллын зардал 1,800.0 мянган төгрөгөөр тус тус буурсан./ -өөр, хангамж, бараа материалын зардал 14,132.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 27,534.3 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 20,184.7 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 2,367,512.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 1,778,308.0 мянган төгрөг / 1,500,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий лабораторийн барилга болон барилгатай холбоотой тогтмол зардал, шинээр худалдан авах техник, тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авах зардлын төсвийг хассан./ -өөр бууруулж, 589,204.7 мянган төгрөгөөр баталсан бол 2021 оны 12 дугаар сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулан 13,948.2 мянган төгрөгөөр бууруулж **575,265.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 575,256.3 мянган төгрөгийн төсөв баталж, тусгай зориулалтын шилжүүлгээс 559,695.3 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 15,561.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 559,695.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 15,561.2 мянган төгрөг зэрэг нийт 575,256.5 мянган төгрөгийн

санхүүжилт авч, урсгал зардалд нийт **574,415.9** мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 840.6 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 574,415.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 787.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 25.3 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 1.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 26.7 мянган төгрөг зэрэг нийт 840.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас 70,000.0 мянган төгрөгийн орлогыг ГЗБГЗЗГ-ын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэлээр 130,100.4 мянган төгрөгийг орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 185.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд зам, барилгын ажлын техник хяналтын зардалд ЗТХЯ-аас 26,403.2 мянган төгрөг, БОАЖЯ-аас 1,110.3 мянган төгрөг, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-аас 59,851.3 мянган төгрөг, Бороо гоулд ХХК-иас 9,491.6 мянган төгрөг, 12 иргэний эзэмшил, өмчлөлийн газрын 48 эргэлтийн цэгийг тогтоосон цэг тэмдэгтийн төлбөрийн 720.0 мянган төгрөг, түлш шатахуун худалдан авах цахим тендерийн хураамж 70.0 мянган төгрөг зэрэг нийт **97,646.4** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс хөрөнгийн буюу 4 айлын орон сууцны барилга худалдан авахад 64,000.0 мянган төгрөг, урсгал зардалд 30,309.3 мянган төгрөг / *Замын гэрээт инженер болон лабораторийн шинжээч нарын цалинд 1,800.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 225.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалын зардалд 4,890.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 3,007.9 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 232.9, БҮТЭЗ худалдан авах зардалд 7,971.3 мянган төгрөг, багаж, техник, хэрэгсэл худалдан авахад 3,800.0 мянган төгрөг, тавилга худалдан авахад 2,200.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,770.3 мянган төгрөг, БГАҮ-ний зардалд 391.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 40.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 980.0 мянган төгрөгийг зарцуулсан.* / -ийг зарцуулж, хэмнэлтийн 3,337.1 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Тайлант онд ковид-19 цар тахлын улмаас Таван хан уул ХХК-иас техник хяналтын зардал 50,000.0 мянган төгрөгийг барагдуулж чадахгүйд хүрсэн бөгөөд тус компанийн эзэмшлийн 2021 онд ашиглалтад оруулсан 190 м² талбай бүхий 4

айлын орон сууцыг 114,000.0 мянган төгрөг / 1 м²-ыг 600.0 мянган төгрөгөөр үнэлсэн./
-өөр үнэлж, аймгийн ГХБХБГ-т борлуулж, дээрх техник хяналтын зардал 50,000.0
мянган төгрөгийг суутган тооцохыг хүссэн албан бичиг ирүүлжээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2021 оны 07 дугаар
сарын 09-ний өдрийн 1/1300 дугаар албан бичгээр албан хаагчдын нийгмийн
асуудлыг шийдвэрлэх хүрээнд дээрх орон сууцны барилгыг 120 айлын орон сууцны
барилгын техник хяналтын зардлын өрөнд тооцож, үлдэгдлийг нэмэлт
санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн техник хяналтын зардлаас 64,000.0 мянган
төгрөгөөр санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна. Энэ нь Барилга хот байгуулалтын
сайдын 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалын хавсралтаар
баталсан “Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах зардлын нэр
төрөл”¹-ийг зөрчсөн байна.

3.7.2 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0”
үлдэгдэлтэй болсон 146,948.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 38 нэр төрлийн
хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “...
дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг
ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай
нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин
үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд
тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал
гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29
дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн
агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор
www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх
үүрэгтэй.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь тайлант онд шилэн
дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллээс 119 мэдээллийг хугацаанд
нь мэдээлж, 30 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

¹ 1.Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах ажлын хөрс, дотоод томилолтын зардал

2.Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах унаа, шатахуун, сэлбэг хэрэгслийн зардал

3.Барилга захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах бичиг хэрэг, шуудан холбооны зардал

4.Барилгын ажлын үе шат бүрд хийгдэх зохиогчийн хяналт 5.Захиалагчийн хяналт хийхэд шаардлагатай компьютер, тоног
төхөөрөмж, хэмжин шалгах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн зардал 6.Барилга байгууламж,
инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн тодорхой хэсэг буюу зангилаа далдлагдсан ажлаас сонгон авч задлан үзэж
магадлан шалгах зардал /Шаардлагатай тохиолдолд/ 7.Барилгын материалын чанарт хяналт тавих лабораторийн хэвийн
үйл ажиллагааг хангах, өргөжүүлэхэд шаардагдах зардал 8.Барилгын инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалт,
хурал, зөвлөгөөн зохион байгуулах зардал 9. Барилгын чанар, аюулгүй байдлын талаар нийтэд ил тод мэдээлэх сургалт,
сурталчилгааны зардал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын тайлант оны үйл ажиллагаанд **575,256.5** мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **574,415.9** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.2 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 8,587.8 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 албан шаардлага, 1,238.8 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлснээс албан шаардлагыг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	8,587.8	2	8,587.8	-	-	100.0
Зөвлөмж	3	1,238.8	2	1,238.8	1	-	
Нийт дүн	5	9,826.6	4	9,826.6	1	-	80.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **21,616.2** мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 5,413.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 778.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоон, 15,425.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах 5,413.0 мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд хангамж, бараа материалын зардлын төлөвлөгөөг 2,707.0 мянган төгрөг, БГАҮ-ний төлбөрийн зардлын төлөвлөгөөг 2,706.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасныг залруулга хийлгэв.

4.2 Төлбөрийн акт

1. Төрийн алба хаасан хугацааг зөрүүтэй тооцож, мэргэжилтэн Ч.Эрдэнэжаргалд 359.7 мянган төгрөг, Ерөө сумын газрын даамал З.Мөнхзаяад 418.3 мянган төгрөг зэрэг нийт **778.0** мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно: 6-10 жил (61-120 сар)-д 5 хувь, 11-15 жил (121-180 сар)-д 10 хувь” гэсэн заалтыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. Анхан шатны болон төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Тайлант онд 14,186.4 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 **Өгсөн зөвлөмж:** Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу

бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ГЗБГЗЗГ-аас 2012 онд баталсан бөгөөд түүнд тусгагдсан зарим хууль тогтоомж, эрх зүйн актуудад өөрчлөлт орж, хүчингүй болсноос шалтгаалан нягтлан бодох бүртгэлийн бодлого нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль эрхийн актын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, мөрдөн ажиллах.

3. Авлагын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Тус газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Уугантуяатай холбоотойгоор 2014 онд үүссэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1,238.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулалгүйгээр, тайлагнасан байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...”, 20.2.6 дахь “ ... төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх...” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул уг авлагын үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, төлөгдөх найдваргүй бол данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	6	21,616.2	2	5,413.0	1	778.0			3	15,425.2